

## НҮҮДЭЛЧДИЙН ХОТ СУУРИН БА ДАВХАР ХЭРЭМТ БАЙГУУЛАМЖИЙН СУДАЛГАА (Дов дэрсийн турийн жишээн дээр)

С. Өлзийбаяр<sup>1,\*</sup>, Э. Уртнасан<sup>2</sup>

**Товч агуулга:** Хэнтий аймгийн Баянмөнх сумын нутаг Жаргалант уулын зүүн урд энгэр Дов Дэрсийн турь болон Монгол нутаг дахь давхар хэрэмт хотын турийн бүтэц зохион байгуулалтын талаар харьцуулан үзэв. Монгол нутагт оршин тогтож байсан эртний улсуудын хувьд давхар шороон хэрэм нь хамгаалалтын нэгэн чухал шийдэл байсан нь археологийн хэрэглэгдэхүүнээр тодорхой болж байна. Дов дэрсийн турийн он цагийг Монголын эзэнт гүрний үед холбогдох магадлалтай хэмээн бид урьдчилан үзэв. Монгол нутгаас илрээд байгаа түүхэн өргөн цаг хугацаа хамарсан давхар хэрэмт байгууламж нь эртний хятад сурвалжид дурдагдсан гадна, дотуур шороон хэрэмтэй хот 城郭 (chéngguō) бололтой хэмээн үзэв.

**Түлхүүр үг:** Нүүдэлчдийн хот байгуулалт, эртний улсууд, хот суурин, давхар хэрэм, Дов дэрсийн турь, дотуур, гадуур хэрэмт хот 城郭 (chéngguō).

### Удиртгал

Нүүдэлчдийн амьдралын хэв маяг нь мал аж ахуй эрхлэлттэй салшгүй холбоотой бөгөөд түүнд зохицсон суурин шинжийг ч зарим талаар илтгэдэг. Тухайлбал, мал аж ахуйн хөдөлмөрийн хэрэгсэл болох мод, шавар сав суулгын үйлдвэрлэл, газар тариалан эрхлэх, тахилга, суртлын буюу оюуны хөдөлмөр эрхлэлт, нийгмийн язгуурлаг давхаргынхны орд өргөө түүнийг дагасан албадлагын хөдөлмөр эрхлэгчдийн төвлөрөл гэх мэт мал аж ахуйтны амьдралаас ургасан “суурин” шинж нийгмийн хөгжлийн явцад салаалан нахиалах болжээ. Ийм хөдөлмөр эрхлэгчид болох дархан мужаан, тариачид, удган зайран, элдэв илбэ жатга үзүүлэгч мэргэ төлөгч “далд удвистан” болон бүл, овгийн ахлагчид, хаад ихсийн орд өргөөнд шадарлагч албан хаагч түшмэд, худалдаачид гэх мэт “мэргэжилтэн”-үүд суурин маягаар аж төрөх болов. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн гүнээс бий болсон хөдөлмөрийн хуваарийн дүнд бойжсон “суурин” шинж нь газар тариалангийн соёлд тулгуурласан сонгодог суурин амьдралаас үндсээрээ өөр болох нь мэдээжийн хэрэг юм.

Өнөөгийн Монгол нутагт дээр дурдсан хэв шинж бүхий нүүдэлчдийн суурин маяг хүрэл зэвсэгтний дунд хэрээс тавигдаж эхэлсэн бололтой. Хэдийгээр тэдний суурин, сууцны үлдэгдлийг хараахан илрүүлээгүй ч олны хүчээр нүсэр том чулуун байгууламж барих, бугын дүрст хөшөө урлах нарийн

мэргэшсэн чулуучид бий болсон зэрэг нь хүчирхэг язгуурлаг давхарга, түүнд үйлчлэх төвлөрөл байсныг илтгэнэ. Хиргисүүрээс эргэх хүрдийн технологийн ул мөр бүхий ваарын хагархай олдсон тухай мэдээ нь суурин керамик үйлдвэрлэлийн жишээ мөн. Эртний Хятадын Байлдаант улсуудын эхэн үед тэдний умард хөрш сяньюань нар олон тооны байлдааны тэрэг олзлуулсан болон шатаасан тухай мэдээ, Монгол орны нутгаар өргөн тархсан хадны зураг дахь тэрэгний дүрслэл зэрэг нь хөгжингүй хүрлийн үед Монгол нутагт амьдрагчид тухайн цагийн шилдэг “инноваци” нутагшуулах эдийн засгийн түвшинд хүрээд байсны илрэл мөн. Тиймээс нүүдэлчдийн дунд язгуурлаг ураг ялгаран гарч, түүнийг хүрээлэн суурин хэлбэрээр үйлдвэрлэлээ явуулах өндөр “мэргэжлийн” чулуучид, сийлбэрчид, тэрэгчин мужаан, дархан зэрэг гар урчууд үйлчлэх болжээ.

Мэдээж нүүдэлчдийн нийгмийн харилцаа гүнзгийрэх хэрээр түүнд тохирсон “суурин” хэв маяг төгөлдөржих нь зүй ёсны хэрэг болно. Археологийн хэрэглэгдэхүүнээс үзэхэд Хүннүгийн үеэс суурин амьдралын гэрч болох гадуураа шороон хэрэмтэй, хэрэмгүй байгууламжийг цогцлоох болсныг археологийн зохиолуудад “хот суурин” хэмээн тэмдэглэж иржээ. Хот суурин нь Хүннүгийн эдийн засагт газар тариалан, төмөрлөг боловсруулалт, вааран эдлэл болон бусад дархан, мужааны ажил нэлээдгүй эрчимтэй хөгжиж байсны илрэл болно. Хүннүгийн хот суурины уламжлалын талаар судлаачид нэгдмэл байр сууринд хүрээгүй бөгөөд нүүдэлчдийн нийгмийн дотоод үйл явцын үр дагаварт бий болсон эсвэл Хятад, Алс Дорнодын нөлөө гэж янз бүрээр тайлбарлаж байна.

<sup>1</sup> МУИС, Археологийн судалгааны төв

\* Холбоо барих зохиогч: [ulziibayar.sod@gmail.com](mailto:ulziibayar.sod@gmail.com)  
<https://orcid.org/0000-0001-7781-6276>

<sup>2</sup> ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн

Ц.Доржсүрэн Хүннүгийн хот байгуулалтыг өөрийн тогтсон хэв маягтай байсан гэсэн санааг манай судлаачдаас анхлан дэвшүүлжээ. Тэрээр “барилгын хана буюу их биеийг үйлдэхдээ чулуун суурьтай модон шонгуудын хооронд шавар дагтаршуулан шааж хийдэг байсан нь Хүннү нарын өөрсдийн барилга барих уламжлал” (Доржсүрэн 2004) гэж үзжээ. С.В.Киселев тухайн цагт судлагдаад байсан Иволгын суурины эздийн талаар саналаа хэлэхдээ Хятадын олзлогсод хийгээд зугтагсад хэрэв барьсан бол бэхлэлт хийх үндэслэл байгаа эсэхэд эргэлзэн Г.П.Сосновский, А.П.Окладников нарын суурин байдал нь Хүннүгийн өөрийн нийгмийн бүтцийн үр дүн гэж үзсэнийг дэмжжээ (Киселев 1957). Хүннүгийн хот байгуулалтын уламжлалыг нийгмийн дотоод хөгжлийн үр дүн гэж үзэх судлаачдын үзэл баримтлал улам бүр гүнзгийрэх болсны нэгэн илрэл нь З.Батсайхан Хүннүд нүүдлийн мал аж ахуй өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангаж чадахгүй болсноос хот суурингууд үүссэн гэж нотлохдоо “Хэрлэн, Орхон, Сэлэнгэ зэрэг томоохон гол мөрний сав дагуу хэд хэдэн том суурин газрыг байгуулж... хүннүгийн суурин газар бүрд оршин суугчдын нэг хэсэг нь газар тариалан эрхэлж байсан” (Батсайхан 2002:195) гэж дурдсан гол мөрний хөндийгөөр Монголчууд эрт үеэс газар тариалан эрхэлсээр ирсэн уламжлалаас үүдэн дүгнэжээ.

Сурвалжид хүннүчүүдийн дунд зугтагсад ба олзлогсод цөөнгүй байсан тухай мэдээ хийгээд Иволгын оршин суугчдын антропологийн хэмжилтийн үр дүнд дулдуйдан А.В.Давыдова хүннүгийн суурин хэлбэрийг хятадын угсаатны хүрэнээс хайсан байна (Давыдова, 1985:49). Иволгын суурины судалгааны зарим үр дүн олон судлаачдыг ийнхүү дүгнэхэд хүргэсэн юм. С.И.Руденко тариалангийн зарим багаж, анжист тариалан, ясан савааны (савх) тусламжтайгаар будаа хүнсэнд хэрэглэх, хятад маягийн хагас нүхэн гэр, керамикийн илүү сайн хэсэг, модон чийдсэн аяга, хүрэл эдлэлийн хэсэг тэгээд мэдээжээр торго бөс зэрэг хятад маягийн зүйлүүдэд үндэслэн хүннүгийн өөрийн суурьшмал хэлбэр нь хятадаас нэвтэрсэн байх боломжтойг үгүйсгээгүй юм (Руденко 1962:114). Хүннү нараас бий болж эхэлсэн хот байгуулалтад “... хятадын нөлөө байсныг үгүйсгэж болохгүй юм. Эл цөөвтөр суурин нь хожим монгол нутагт хот үүсэж хөгжиж, суурьшлын хэсэг, хэсэг голомт буй болоход нөлөөлсөн байж болох” (Сүхбаатар 2000: 39) талтайг Г.Сүхбаатар чухалчлан үзжээ. Сүүлийн жилүүдэд Тэрэлжийн дөрвөлжин, Гуа Дов зэрэг Хэрлэнгийн сав дагуух хотуудаас хятад зүгийн хийц, донж маяг бүхий барилгын чимэглэл олон тоотой илэрч байна. Эдгээр хотуудын он цагийг лабораторийн аргаар тооцоход харьцангуй өндөр буюу НТӨ II зууны тэргүүн хагас буюу Иволгын суурингийн он цагтай ойролцоо харин

цагариг далант болон язгууртны булшны дундаж он цагаас эрт байгаа нь анхаарал татахгүй байх аргагүй юм.

Иволга, Дурень, Бороогийн суурингуудаас илэрсэн халуун ханз (炕 kàng) бүхий хагас нүхэн гэр, ваар савны зарим хээ чимэглэл зэрэг Алс Дорнодоос уламжлалтай шинж тэмдгүүдээр Хүннүгийн суурин амьдралын эхлэлийг холбон үзэх саналтай эрдэмтэд цөөнгүй бий. Ханз буюу кан нь зөвхөн хятадын соёл бус Примор, Солонгосын хойгоор кроун, тхэсонри (Солонгос), дээд Сяцзянь зэрэг соёлын хүрээнд Алс Дорнодын нутгаар төвлөн өөрийн жамаар хөгжжээ (Бродянский 1985). Б.Б.Дашибалов үзэхдээ археологийн хэрэглэгдэхүүнээр хүннүгийн соёлд нүүдлийн ба суурин ертөнцийн хоёр уламжлал байгааг онцлоод суурин уламжлал нь Зүүн Азийн язгууртай Алс Дорнодын орчинтой хамгийн нягт уялдаатай бол хүннүгийн нүүдлийн зан үйлийн эх нь эсрэгээр нөгөө талаас Ираны хүрээний барууны соёлын ертөнц гэжээ (Дашибалов 2003). Зарим судлаачдын Хүннүчүүдийн суурин амьдралын гэрч болгон үзэж байгаа ханзан халаалттай хагас нүхэн сууцны гарлыг Амар хавь, Алс Дорнодын бүс нутагтай шууд холбон үзэх үндэслэл сул байна. Учир нь НТӨ III - НТ II зууны хооронд буюу Хүннү улстай мөр зэрэгцэн оршиж байсан Алс Дорнодын Приморийн өмнөд, Хятадын зүүн хойд хэсэг, Солонгосын хойгийн хойд хэсгээр оршиж байсан Кроуний соёлын сууцанд халаах байгууламж болох чулуун ханз тархаж байжээ. Энэ хоёр зэрэгцэн оршиж, өргөн харилцаатай байсан нь тодорхой ба ялангуяа Дунбэй хавийн аймгууд Хүннүгийн харьяанд орж байсан нь харилцан нөлөөлөх учир шалтгаан болсон нь тодорхой. Төв Азийн олон угсааны ард түмэн, Дунбэй хоорондын өргөн хүрээтэй харилцаа нь сууц барих технологи, халаалтын бие даасан системийн ойролцоо шийдэлд хүргэсэн хэмээн археологичид үзэж байна (Бродянский 1985). Дээрх хэрэглэгдэхүүнээс дүгнэхэд Хүннүчүүдийн дунд чулуун ханз бүхий гэрт суугчдын соёл Алс Дорнод хавиас нэвтэрсэн гэх шууд нотолгоо болохгүй харин нэгэн цаг үед харилцан хоёр биедээ нөлөөлсний улмаас дурдсан нутгуудад тархаж байсан нь л тодорхой байна. Хятад сурвалжийн мэдээнд Хань улсын жанжин Сү Ү (苏武) Хүннүд олзлогдон 19 жил болохдоо өвлийн хахир хүйтнийг хэрхэн даван туулдаг байсан талаар “凿地为坎，置煖火” (zao di wei kan, zhi wen huo) хэмээх Хань улсын судрын мэдээг “Газарт нүх ухаж, галд дулаацдаг” гэсэн утгатай хэмээн Г.Батболд тайлан уншжээ (Батболд 2013). Энэ мэдээ нь магадгүй халуун ханзны талаар өгүүлсэн байж болох юм.

Судлаачдын хийсэн дүгнэлтээс үзэхэд Хүннүгийн суурин амьдралын хэв маяг нь Хятад болон Алс Дорнодын нөлөөтэй байж болох дүр зураг харагдах боловч нөгөө талаар нүүдэлчдийн амьдралын шаардлагаар бий болж, цаашид өөрийн замаар

хөгжих болсныг үгүйсгэж үл болно. Ялангуяа дараа үеийн нүүдэлчдийн хот байгуулалтын уламжлалаас энэ нь илүү тодорхой мэдэгдэнэ. Хүннүгээс хойш нүүдэлчдийн аж ахуйд суурьшмал амьдралын хэв маяг эрс багасах болсон нь хот суурин байгуулалт бараг үгүй болсны зэрэгцээ суурин нөхцөл шаардах технологи бүхий ахуйн зарим төрлийн бүтэгдэхүүнийг хийхээ больсноос харагдана. Тухайлбал, нүүдлийн сонгодог мал аж ахуйг цэцэглүүлсэн Жужанчуудад тусгайлан хот, суурин газар байгуулах хэрэгцээ эхэн үедээ байгаагүй ч нүүдэлчдийн эдийн засгийн эрэлт шаардлагаар хот суурин байгуулах хэрэгцээ гарах болов. Энэ талаар Вэй улсын сударт:

Жужанчууд аажим боловч байнга сулран доройтсоор байв. Юн-Мин (483—493)-ийн үед өндөр тэрэгтнүүдэд бут цохигдон эзэмшил нутаг нь хумигдан, өмнө зүгт шилжин нутаглав. Тянь-цзянь (502—519)-ий үед жужанчууд дахин сэргэж, Өндөр тэрэгтнүүдээс булаагдсан нутгаа эргүүлэн олж авч, анх удаа гадна, дотно хэрэмтэй хот байгуулан түүнийгээ Мумочэн гэж нэрлэсэн (Таскин 1984: 288-289) талаар дурджээ. Ийнхүү хот суурин байгуулах шаардлага гарсан нь тэдний нийгмийн дотоодын эрэлтээс үүдэлтэй нь эргэлзээгүй бөгөөд хүчирхэгжих болсон цагаас ийнхүү хот барих болсон нь ажиглагдаж байна. Жужан нүүдэлчид жилийн дөрвөн улирлын туршид бэлчээр сэлгэн нүүдэллэж, малынхаа мах, сүүг хүнсэнд хэрэглэхийн ялдамд арьс ширийг нь боловсруулан гутал хувцас, адуу малын тоног хэрэгсэл, богц сав, цэргийн зориулалтаар ашиглаж байв. Ноос, хөөвөр, дэл сүүлээр эсгий, дээс шидэмс хийн нүүдэллэхүүд тохирсон хөнгөн авсаар гэр сууцаа төхөөрөн, оймс малгай зэрэг эсгийгээр хийж болох хувцас хийж өөрсдийн ахуйн хэрэгцээг бүрэн хангаж чадаж байжээ. Тиймээс Жужанчууд хот суурин амьдралын хэлбэр төдий л эс шаардах малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах гэрийн үйлдвэрлэл хөгжүүлэн оршин тогтнож чадаж байжээ (Өлзийбаяр, Энхбат 2017: 168-169). Энэ нь Дотоод Азийн нүүдэлчдийн олон үеийн туршид оршин тогтож ирсэн амьдралын хэв маяг болно.

Монгол оршуулгаас одоо хэр “Монголын” гэж тодорхойлж болох өөрийн технологитой шавар ваар олдоогүй байна. Энэ нь нэг талаар шавар ваарыг гэр зуурын нөхцөлд, нүүдэл суудлын далимд хийчихдэг ажил биш болохыг харуулж буй хэрэг бөгөөд шавар вааран урлал хөгжсөн Хүннү мэтийн нийгэмд хот байгуулах үзэгдэл их байсан нь эл ажилтай холбоотой байж болох билээ. Мал аж ахуй сонгодог хэлбэрээ олох тусам суурин маягийн аж ахуйн олон хэлбэр шахагдан нүүдлийн соёлд илүү нийцсэн төрхийг олсны дотор дундад зууны Монголчуудад шавар ваар өргөн хэрэглээнээс хасагдаж, урлахад илүү хялбар модон болон ширэн уут сав, нүүдлийн аян

даах ширмэн тогоо зэрэгт халаагаа өгсөн байна. Мөн энэ зүй тогтлыг дагаад нүүдэлчдийн хүнсний хэрэглээ мах, сүүн бүтээгдэхүүн, зарим ургамал, жимсээр хязгаарлагдах болж ан, малын гаралтай түүхий эдээ боловсруулан хувцас хийж хэрэгцээгээ хангадаг иж бүрэн тогтолцоонд хүрчээ. Тиймээс газар тариалангийн бүтээгдэхүүн сонгодог нүүдлийн мал аж ахуйн нөхцөлд хүн амын хүнсний үндсэн хэрэгцээ болж эс чадах хэмжээнд хүрсэн байж болох билээ.

Эндээс бид дүгнэж үзэхэд “...нүүдлийн мал аж ахуйн хөгжлийн үрээр малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэн аж ахуйн бусад салбаруудын үүрэг, ач холбогдол буурахад” (Өлзийбаяр 2006) хүргэдэг байж болох зүй тогтол Хүннүгийн дараах улсуудын нийгэмд ажиглагдаж байна. Иймээс бид судлаачдын сонгодог гэж тодорхойлсон Монгол нутагт оршиж асан нүүдэлчдийн мал аж ахуйг дотор нь а/ суурин аж ахуйн салбартай хоршсон Хүннү маягийн (үүнд хүннү, уйгур, Хятаны мал аж ахуйг тооцож болох мэт) б/ аж ахуйн бүх салбарууд нь нүүдлийн соёлд зохицсон Монгол маягийн нүүдлийн сонгодог мал аж ахуй гэж хоёр хуваан үзэж болох байна. Эдгээр нүүдлийн мал аж ахуйн хэлбэрүүд нь бүгд хүн амынхаа үндсэн хэрэгцээг хангах чадвартай байж “сонгодог” хэмээн тодорхойлогдож байгаа билээ. Жужанчуудад эхэн үедээ гадна, дотно хана хэрэм бүхий хот суурин байхгүй байсан нь тэдний нийгэмд дотоодын худалдаа арилжаа, төмөрлөг болон шаварлаг эдлэл боловсруулах гар урлалын үйлдвэрлэл сул хөгжсөн болохыг харуулах төдийгүй энэ нь бүхэлдээ монгол маягийн нүүдлийн сонгодог аж ахуйн нийтлэг төрх болно. Төмөрлөг тогоо, сав суулгаас гадна нутгийн гаралтай модон эдлэл (тагш, бортого, дашмаг, торх г.м), малын гүзээ<sup>1</sup> зэрэг бүтээгдэхүүнээр шаварлаг эдлэлийг бүрэн орлуулах хэмжээнд гэрийн үйлдвэрлэл хөгжсөн нь нүүдэлчдийн монгол маягийн аж ахуйн хэлбэрийн онцлог болно.

Газар тариалан эрхлэлт зэрэг суурин аж ахуйн уламжлалыг хөгжүүлсэн нүүдэлчдийн дараагийн улсууд болох Уйгур, Хятан болон Монголын эзэнт гүрний үед бүтээсэн хот суурины турь олон тоотой байгаа бөгөөд их төлөв эрт цагаас нүүдэлчдийн газар тариалангийн бүс нутаг болсоор ирсэн Сэлэнгэ, Орхон мөрний сав, Хэрлэн, Туулын хөндийгөөр төвлөрч байна. Эдгээр хотын турь нь тухайн цаг үеийн архитектурын өвөрмөц онцлогоор ялгардаг боловч олон зууны туршид тогтвортой хадгалагдсан

<sup>1</sup> 2015-2016 онд ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн “Онон” хээрийн судалгааны баг Хэнтий аймгийн Батишрээт сумын нутаг Зуух-Баян голын Улаан үзүүр, Эрхий толгойд дундад зууны нүүдэлчдийн үлдээсэн байж болох бүлэг дөрвөлжин хашлага бүхий байгууламжид малын гүзээ байсан бололтой органик гаралтай саванд үнс хийж тахилга хийсэн дурсгал тус бүр нэгийг малтан судалсан билээ

зарим нэг бүтэц, онцлог байгууламж бий. Эдгээрийн нэг нь Хүннүчүүдийн хот байгуулалтаас эхлэн Чин гүрний цэргийн бэхлэлт хүртэл бүх цаг үеийн туршид уламжлагдсан давхар шороон хэрмийн бүтэц болно.

### Дов дэрсийн турийн тодорхойлолт

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн “Хүннүгийн дараах нүүдэлчид” суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд 2019 оны зун Хэнтий аймгийн Баянмөнх сумын нутаг дахь Дов дэрсийн турийн археологийн хэмжилт, дэвсгэр зургийг анх удаа үйлдэв. Сумын төвөөс баруун тийш 30 км алслагдсан Хэрлэн голын урд дэнжид Жаргалант уулын зүүн урд хормойд (46°55'39.44"N, 109°24'1.12"E) байрлана. Тус хэрмийн турийн ойр орчинд дэрс шигүү ургасан, харьцангуй өндөрлөг газар тул нутгийнхан Дов дэрс хэмээн бас нэрийднэ.

Хэрмийн турь дөрвөлжин зохиомжтой, шавар дэлдэж хийсэн давхар хэрэмтэй бөгөөд зүүн, баруун талдаа хаалганы оромтой. Хэрмийн баруун хойд хана Хэрлэн голын хуучин голдиролд идэгдэж үгүй болсны зэрэгцээшороон далангийн дээр болон дотор, гадуур дэрс нэлээд ургасан нь байгууламжийн хадгалалтад нөлөөлсөн байна. Хэрмийн дөрвөн талын гадна ханын үлдэц гайхамшигтай тэгш буюу тус бүр 215 м урт төдийгүй далангийн өргөн мөн нэгэн жигд ба дунджаар 8 м бол түүний өндөр нь 0.8-1 м байна. Гадна хэрмийн дотуур 8 м өргөн, 1 м гүн суваг үлдсэн нь хэрмийн далан барихад ашигласан хөрс хуулалтаас үлдсэн бололтой. Шавар хэрмийн дотор талын давхар хэрэм нь 100 х 110 м хэмжээтэй, 8 м өргөн, 0.5-0.8 м өндөр. Дотор хэрэм нь гадна хэрмээс дотогш 30 м зайтай. (Зураг 1)

Хэрмийн урд болон зүүн хана харьцангуй бүтэн үлдсэн бол бусад хэсэг нь нэлээд эвдэрч олон хэсэг газар тасарсан байна. Хэрмийн дотор барилга, байгууламжийн үлдэц мэдэгдэх зүйлгүй бөгөөд ногоон паалантай ваар, мөн өнгийн пааландсан шаазангийн хагархай, цагаан шаргал хар судалтай шаазангийн хагархай бага зэрэг түүвэр байдлаар олдсоноос өөр ямар нэгэн он цаг тогтоож болохуйц эд өлгийн зүйл илэрсэнгүй.

Бид тус хэрмийн дотор талд булан, төв хэсэгт, үүдний хавьцаа зэрэг хэд хэдэн газар багахан талбайгаар сорилтын малтлага хийсэн боловч мөн л тодорхой үр дүнд хүрсэнгүй.

### Түүвэр олдворын тодорхойлолт

ДД-1. 8 ширхэг ваарын хагархай. Өнгөн талдаа ногоон алаг, бор паалантай, дотор тал нь бор өнгийн паалантай. Эдгээрийн 1 нь ёроол хэсгийн жижиг хагархай бол бусад нь бөөр хэсгийн хагархай болно.

4.5 х 5 см, 3.5 х 2 см гэх мэт харилцан өөр хэмжээтэй байна. Зузаан нь нэгэн жигд 0.7 см аж. Хадгалалт дунд зэрэг. (Зураг 2.1)

ДД-2. Ваарын хагархай 2 ширхэг, гурвалжин хэлбэртэй хоёр талын гадарга жигд бор өнгөтэй, нарийн ширхэгтэй шавраар хийсэн байна. 3 х 2.5 см хэмжээтэй, 0.8 см зузаан. (Зураг 2.2)

ДД-3. Өнгөн тал нь бор өнгийн паалантай боловч анх хийхдээ урсаж ямар нэгэн хээтэй мэт дүрс үүсгэсэн байна. Дотор тал нь мөн бор өнгийн паалантай. Тус ваарын хагархай нь нарийн ширхэгтэй цагаан шаргал шавраар хийжээ. 4 х 2.6 х 0.7 см хэмжээтэй. (Зураг 2.3)

ДД-4. Цайвар ногоон өнгийн паалантай шаазан ваарын амсар хэсгийн 2 ширхэг хагархай. Тус шаазангийн хагархайг нарийн ширхэгтэй цагаан шавраар хийжээ. Том нь 3.5 х 3.5 см, жижиг нь 2 х 2.2 см хэмжээтэй, амсар нь 0.8 см, бусад хэсгээрээ 0.3 см зузаан. (Зураг 2.4)

ДД-5. Цагаан паалантай шаазан ваарын хагархай. Цагаан шаргал өнгийн нарийн ширхэгтэй шавраар хийжээ. 1.8 х 1.6 х 0.5 см хэмжээтэй. (Зураг 2.5)

ДД-6. Өнгөн алдаа өргөн, нарийн хар зураасан хээтэй, цагаан паалантай ваарын хагархай. Дотор тал нь бор алаг паалантай, нарийн ширхэгтэй бор саарал өнгөтэй. 2.7 х 2.6 х 0.6 см хэмжээтэй (Өлзийбаяр нар 2019). (Зураг 2.6).

Хүннүгээс Чин гүрэн хүртэл өргөн цаг хугацааг хамарсан давхар хэрэм бүхий зохион байгуулалттай Дов дэрсийн байгууламжийн адил турийн үлдэгдэл Монгол, Өвөр Байгал, Тувагийн нутгаас л гэхэд цөөнгүй тэмдэглэгдээд байна. Тухайлбал, Хүннүгийн үед хамаарах давхар хэрэмт байгууламж ОХУ-ын Буриадын нутагт Баян-Өндөрийн суурин (Данилов 2004: 37-38), Иволгын суурин (Давыдова 1995), Монгол улсын Архангай аймгийн Өлзийт сумын нутаг дахь Харганын дөрвөлжин (Идэрхангай нар 2020), Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Мангасын хүрээ (Амартүвшин нар 2009) мөн Уйгурын үеийн зарим хотууд давхар хэрэмтэй байгаагаас Архангай аймгийн Хотонт сумын нутаг дахь Цагаан сүмийн балгас-1, ОХУ-ын Тувад буй Шагонар-III (Кызласов 1969:61-62) зэрэг болно. Хятаны үед хамаарах Монгол, Хятад, ОХУ нутаг дэвсгэрийг дамнан орших Чингисийн хэрмийн дагуу нийт 56 бэхлэлт байгаагаас 10 бэхлэлт нь давхар хэрэмтэй (Крадин и др. 2020: 76-77) бол Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын нутаг дахь Хубилай хааны цэргийн сүрийг бадруулагч хот буюу Хөгшин Тээлийн балгас нь XIII-XIV зууны үеийн мөн дурсгалын төрөлд хамаарах сонгодог жишээ юм.


Харин Чин гүрний үеийн байгууламжуудад цэргийн зэвсэглэлд галт бууны технологи нэвтэрсэнтэй холбогдоод давхар бэхлэлтийн үүрэг буурсан тал ажиглагдаж байна. Тухайлбал, үндсэн хэрмээс гадагш




30-60 м зайтай хамгаалалтын суваг татах болсон нь эдүгээ давхар хэрмийн үлдэц мэт харагдах ажээ. Үндсэн шавар хана болон суваг хоорондын зайд олон жижиг хонхор мэдэгдэж байгаа нь магадгүй нүхэн гэр болон зөөврийн хөнгөн сууц барьж цэрэг суудаг байсныг илтгэж байгаа нь мөн үеийн бэхлэлтийн онцлог тал хэмээн үзэж болно. Эдгээрээс Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дахь Хар бондгор буюу Орхон хот, Архангай аймгийн Цэцэрлэг хотоос холгүй Тамир голын хойд хөвөөд оршин Тамир хотын турь, Завхан аймгийн Алдархаан сумын нутагт орших Өгөөмөрийн хотын турь зэргийг жишээ болгон дурдаж болох юм.

## Монгол нутаг дахь давхар хэрэмт хотын турь

**Харганын дөрвөлжин (Хүннү):** Архангай аймгийн Өлзийт сумын төвөөс баруун урд зүгт 10 км орчим зайд, Орхон, Тамирын бэлчрээс ялимгүй баруун хойд зүгт 27 км орчим зайд Харганын хөндий гэдэг газар байрлана. Төв хэрэм нь харьцангуй сайн хадгалагдсан 265 х 200 м хэмжээтэй бол төв хэрмийн гадуур давхар хэрэм үйлдсэн боловч түүний урд хэсэг нь бүхэлдээ тариан талбайд өртсөн бол харин баруун, зүүн хэсгүүдийн тал, хойд хана бүрэн мэдэгдэж байгаа тул түүний урт 553 м байна (Идэрхангай нар 2020). (Хавсралт 1.2)



Зураг 1. Дов дэрсийн хэрмийн турийн дэвсгэр болон сансрын зураг



Зураг 2. Дов дэрсний турias түүвэр байдлаар илэрсэн олдворууд

**Мангасын хүрээ (Хүннү):** Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг, Галбын говьд улсын хилээс хойшоо 10 км гаран зайд, эртний 2 том голын салааны дундах арал хэсэгт байрлана. Гол хэрэм нь 130 х 130 м хэмжээтэй дөрвөлжин хэлбэртэй. Сонирхолтой нь энэхүү дөрвөлжин хэрмийн гадна талд харьцангуй урт 595 м орчим голчтой дугуй хэлбэрийн давхар хэрмийн үлдэгдэл мэдэгджээ. Мангасын хүрээ нь гадна талаар дугуй, түүний төв хэсэгт харьцангуй жижиг дөрвөлжин хэрэмтэй тул “зоос”-той төстэй харагдана. Мангасын хүрээ орчмоос төмөр шилбэтэй хүрэл зэв, у-шу зоос зэрэг Хань улсын хийцийн эд зүйлс цөөнгүй олддог. Нутгийн иргэдийн яриагаар эндээс бүхэл бүтэн агуулах гэмээр хүрэл зэв, хүрэл зоос зэрэг илэрч байсан гэдэг. Энэ дурсгал нь Баянбулагийн турьтай ойролцоо цаг үед буюу НТӨ II зууны төгсгөлөөс НТ I зууны үед холбогдох боломжтой (Эрэгзэн, Энхболд 2020: 84-85) хэмээн судлаачид үзсэн байна. (Хавсралт 1.3)

**Сайрын балгас (Хүннү):** Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын төвөөс баруун хойд зүгт 30 км зайд Их Хачиг уулаас зүүн хойш сунаж тогтсон багахан толгодын ар хормойд байрлана. Нутгийнхан “Өртөө ноёны харуулын балгас”, “Сайрын балгас”, “Балгас” хэмээн янз бүрээр нэрлэнэ. Улаан шороог дагтаршуулан хийсэн давхар хэрэмтэй бөгөөд дотоод хэрэм 148 х 140 м хэмжээтэй бол гадаад хэрмийн зүүн баруун болон урд тал тодорхой мэдэгдэх бол хойд хана нь голын сайрт тулж баларчээ. Гадаад хэрмийн хэмжээ нь урд хана 320 м, зүүн хана 300 м, баруун хана 260 м урт хэмжээтэй (Эрэгзэн, Энхболд 2020:84-85). (Хавсралт 1.4)

Эдгээрээс гадна Хүннүгийн үед холбогдох дөрвөн давхар хэрэмтэй Иволгын суурин (Давыдова 1995), хоёр давхар хэрэмтэй Баян-Өндөрийн балгас (Данилов 2004: 37-38) зэрэг дурсгал ОХУ-ын Буриадын нутагт бүртгэгдсэн.

**Цагаан сүмийн балгас-I (Уйгур):** Архангай аймгийн Хотонт сумын төвөөс баруун урагш 50 орчим км зайд, Цагаан сүмийн голын эхэнд намгийн хойд дэвсгэ дээр байрлана. Цагаан сүмийн балгас -I нь баруунаас зүүн тийш хандуулан шавар дагтаршуулан барьсан дөрвөлжиндүү бүтэцтэй, 160 х 120 м орчим хэмжээтэй үндсэн хэрэмтэй. Эл хэрмийн хойд талд 3, баруун талд 2, өмнө талд 3, дөрвөн өнцөгт тус бүр нэгжгээд, бүгд 12 гадагш түлхсэн шороон цонжтой. Том хэрмийн дотор давхар шороон хэрэм бий. Түүний хэмжээ нь ойролцоогоор 100 х 80 м. Эл дотоод хэрэм нь хойноо 2, өмнөө 2, баруун талдаа 1, дөрвөн өнцөг бүртээ нэгжгээд, бүгд 9 гадагш түлхсэн цонж маягийн овгортой. Мөн дотоод хэрмийн үүд нь зүүн талдаа, гадаад том хэрмийн үүдний зүгт байрлажээ. Цагаан сүмийн балгасанд Уйгурын хотуудад нийтлэг ажиглагддаг гадна болон дотор талын суваг шуудуу

огт мэдэгдэхгүй байна (Очир нар 2020: 160-161). (Хавсралт 1.5)

**Чингисийн далан (Хятан):** Монгол улсын дорнод хэсгээр Монгол, Хятад, ОХУ-ын нутгаар дамнан орших Хятаны үед холбогдох Чингисийн далангийн дагуу нийт 56 бэхлэлт суурин тэмдэглэгдсэн бөгөөд эдгээрээс 10 нь давхар хэрэмтэй. Чингисийн далан нь Хятаны умард хэсэгт орших нүүдэлчдээс сэргийлж барьсан хилийн шугам (Крадин и др. 2020: 76-77) гэдгийг судлаачид нэгэнт тогтоосон байна. Тухайлбал, Хэрэмтийн хөндий-1 хэмээх турийн гадна хэрэм 106 х 112 м, дотор хэрэм нь 30 х 30 м хэмжээтэй бол Урд гэрийн говь хэмээх турь нь 160 см голчтой, гадуураа дугуй хүрээ бүхий хэрэмтэй бол дотор талдаа хоёр давхар дөрвөлжин хэрэм байх бөгөөд том нь 60 х 60 м, жижиг нь 30 х 30 м хэмжээтэй байна. Мөн Хар нуур-1 хэмээх дурсгалын гадна хэрэм нь 105 х 107 м, дотор хэрэм нь 30 х 30 м хэмжээтэй байна. (Хавсралт 1.6-8)

**Хөгшин Тээлийн балгас (Монголын эзэнт гүрний үе):** Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын нутагт Хан хөгшин ууланд Хөгшин Тээлийн балгас буюу Хубилай хааны сүрийг бадруулагч цэргийн хот оршино. Энэхүү турь нь тус бүр 2-3 давхар хэрмээр хүрээлэгдсэн 3 хэсгээс бүрдэнэ. I хэрэм 700 х 700 х 770 х 580 м, II хэрэм 430 х 350 х 450 х 460 м, III хэрэм 700 х 700 м дөрвөлжин. Тухайн балгасаас илэрсэн хөшөөний бичээсэнд үндэслэн Хубилай хааны үед түүний цэргийн жанжин болох Хуай мөрний зүүн этгээдийн дэд Юань-шуай, зүүн жигүүрийг хамгаалах шадар цэргийн захирагч сайд Цямангудай 1278 онд шилдэг хурц шадар цэргийг дагуулан умар зүг байлдахаар гараад Иду ууланд хүрээд тэр газраа хот суурин байгуулсан бололтой (Хандсүрэн 1966) хэмээн үзсэн байна. Д.Баяр бага хэмжээний малтлага хийж, олон жилээр хүн байнга оршин сууж байсан шинж тэмдэггүй, түр зуур аян дайны зориулалтаар бэхлэн барьсан шинжтэй гэж үзээд хэрмэн дотор буй олон хонхорт хятад цэргүүд сууж, голын цулгүй хэсэгт монгол цэргүүд гэр, майхан барьж сууж байсан бололтой (Баяр, 2002) хэмээн үзжээ (Хавсралт 1.9-11).

**Манжийн цэргийн бэхлэлт:** XVIII зууны эхэн хагаст манжууд халх нутагт их төлөв өмнө тариа тарьж байсан суурин газар цэргийн хот, цэргийн тариалан байгуулж эхэлсэн хэмээн зарим эрдэмтэд үзсэн байна (Пэрлээ 1961). Орхон хотын гадна талын суваг болон дотор хэрэм 955 х 955 м ба 855 х 855 м. Тамир хотынх ойролцоогоор 860 х 860, 770 х 770 м. Өгөөмөрийн хотын гаднах суваг ойролцоогоор 570 х 570 м, дотор хэрэм нь 460 х 460 м хэмжээтэй.

**Давхар хэрэмт хотын шинж:** Монгол улсын нутагт Хүннү гүрний үеийн 17 хот, суурины үлдэгдэл мэдэгдээд байгаа бөгөөд тэдгээрийг ихэнх нь ертөнцийн тэгш хэмийн дагуу бус, гол төлөв зүүн урагш чиглэлтэй, хэрмийн дотор харилцан өөр

хэмжээтэй барилгын турь мэдэгддэг онцлогтой. Түрэг, Уйгурын үеийн 16 хот, суурины үлдэгдлийн дийлэнх нь мөн л зүүн урд зүг харсан, хэрмийн дотор ямар нэг хэмжээгээр барилгын үлдэгдэл, овгор мэдэгдэж байдаг. Хятан гүрний үед Монгол аймгуудын нутагт байгуулсан 25 хэрэм мэдэгдэх бөгөөд тэдгээрийг мөн л ертөнцийн дөрвөн зүгийн бус баруун урагш, зүүн урагш хандуулсан байна. XII-XIII зууны үед холбогдох судалгааны эргэлтэд орсон 20 орчим хот, суурины үлдэгдэл буй бөгөөд тэдгээрийн цөөн хэд нь тэгш өнцөг хэлбэртэй, ертөнцийн зүг чигийн дагуу байгуулсан байна. Тухайлбал, Барс хот III буюу Тогоонтөмөр хааны хот, Цантын эртний хотын турь, Хөгшин Тээлийн балгас зэргийг дурдаж болно. Манжийн эрхшээлийн үеийн засаг захиргааны том төв болон цэргийн сууринуудын зарим нь тиг дөрвөлжин, ертөнцийн зүг чигийн дагуу байгуулсан нь Сангийн хэрэм, Тамирын хот, Өгөөмөрийн хотын турийн жишээнээс харагдана. (Хавсралт 1.12-14).

“Түүхэн тэмдэглэл” дэх Хүннүчүүдтэй холбогдох 逐水草遷徙，毋城郭常處耕田之業，然亦各 有分地 гэх мэдээг В.С.Таскин “Усны тунгалаг, бэлчээрийн сахлаг хөөж нэгээс нөгөө рүү нүүдэллэх тул байнгын суурин, дотуур, гадуур хана хэрэмтэй хот байхгүй, газар боловсруулдаггүй боловч хувь газартай” (Таскин, 1968:34) хэмээн орчуулсан бол Сун улсын судар дахь Жужанчуудтай холбоотой 無城郭，隨水草畜牧，以穹廬為居 гэх энэ мэдээг “Тэдэнд дотуур, гадуур хана хэрэмтэй хот байхгүй, ус бэлчээр даган нэгээс нөгөөд нүүдэллэнэ” хэмээн орчуулжээ (Таскин 1984: 288-289).

Хүннү, Жужаны хот суурины талаар тэмдэглэсэн дээрх хоёр мэдээнд дурдаж буй 無城郭 (wú chéngguō) -г “Гадна, дотно хэрэмтэй хот байхгүй” хэмээх утгаар дүйцүүлсэн байна.

Бидний судалгаанд хамрагдсан давхар хэрмийн үлдэц нь магадгүй эртний хятад сурвалжид ийнхүү тэмдэглэгдсэн 城郭 (chéngguō) “гадна, дотно хэрэмтэй хот” хэмээх суурин газрын үлдэц байж болно. Дан шороон хэрэмт байгууламжийг эхэн үедээ Хятадын улсууд “гадна, дотно хэрэмтэй хот” буюу chéng хэмээн тооцдоггүй байсан учраас эртний нүүдэлчдийн улсыг “дотуур, гадуур хэрэмт” хотгүй хэмээн онцолсоор ирсний учир энэ бололтой. Хэрэв бид энэ үүднээс асуудалд хандвал манай нутгаас илрээд байгаа давхар хэрэмт туриуд нь Хятад сударчдын онцлон дурдсан хотын шалгуурыг хангасан, 城郭 (chéngguō) байсан гэж үзэж болно.

Археологийн хэрэглэгдэхүүнээс үзэхэд нүүдэлчдийн эртний улсуудын хот суурин цогцлоох арга барилд нэгээс нөгөөд уламжлагдсан бүтэц багагүй байсны дотор давхар хэрэм үйлдэх уламжлал ихээхэн онцлогтой байна. Давхар хэрэм хамгаалалтын зэрэглэлийг сайжруулах нэгэн өвөрмөц шийдэл гэж

үзэх нь зүйтэй юм. Тухайлбал, Харганын дөрвөлжин хэмээх дурсгалыг улсын нийслэл буюу Шаньюйн орд өргөө байсан хэмээн түүнийг малтан судалсан эрдэмтэд үзсэн бол Сайрын балгас, Мангасын хүрээ зэрэг нь хилийн бэхлэлт суурин болох ажээ. Уйгурын үед холбогдох Цагаан сүмийн балгас I давхар хэрэмтэй туурийг тухайн үеийн язгууртны суурин гэж тайлбарласан байна. Монголын эзэнт гүрний үед холбогдох Хөгшин Тээлийн балгасыг Хубилай хааны цэргүүд байгуулсан талаар тэнд босгосон хөшөө чулуунд тэмдэглэсэн тухай бид өмнө өгүүлсэн билээ. Манжийн эрхшээлийн үед өнөөгийн Монгол нутгийн төв, баруун аймгийн нутгаар цэрэг, засаг захиргааны томоохон суурингууд бий болсон бөгөөд тэдгээрийн зарим нь давхар хэрэм, сувагтай байсан нь тодорхой байна. Ийнхүү Монгол нутаг дахь давхар хэрэмт хот, суурины судалгааны байдлаас үзэхэд үе үеийн нүүдэлчдийн хаад, язгууртны болон цэрэг дайны зориулалтаар нэмэлт бэхлэлт хийдэг уламжлал болох ажээ. Ийм зориулалт бүхий хэрэмт хот нь эртний хятадуудын 城郭 (chéngguō) хэмээх гадна, дотуур хэрэмтэй хот мөн болно. Нүүдэлчдийн нийгмийн ялгарал, дотоод хөгжлийн үр дүнд давхар хэрэмт хот, бэхлэлтийн шаардлага урган гарах болсныг бидний энэ удаад өгүүлэн буй жишээ тодорхой харуулсан хэмээн дүгнэн үзэж байна.

Дов дэрсийн турийн он цагийн хамаарал: Бидний судалгааны эргэлтэд оруулж буй Дов дэрсийн хэрэм ертөнцийн зүг чигийн дагуу байрласан, тэгш өнцөгт, тиг дөрвөлжин байгууламж болно. Энэ нь Монголын эзэнт гүрний үеийн хот байгуулалтын нэгэн шинж ертөнцийн их талууд руу зөв байрлах уламжлалыг давтсан хэлбэр болно. Эндээс цөөн тоотой илэрсэн шаргал, ногоовтор өнгийн вааран эдлэлийн хагархайнуудыг нарийн ширхэгтэй шаргал элсэрхэг шавар шатааж хийсэн ба заримын дээр өргөн болон нарийн хос зураасан хээгээр хүрээлжээ. Савны гадна талыг паалантсан байна. Үүнтэй адил хул шаргал өнгийн cizhou хийцийн паалантсан хавтгай таваг, аяга Хархорумын малтлагаас цөөнгүй илэрсэн бөгөөд судлаачид үүнийг Алтан (1115-1234), Си Ся (1038-1227) зэрэг улсын шавар шатаах зуухны бүтээгдэхүүн дээр байдаг хээтэй адилтган үзжээ (Чингис хааны, 2021:221-224, 232). Хээ чимэглэл дүрсэлсэн будгийн өнгө нь төмрийн орцны хэмжээнээс хамаараад шатаалтын явцад хар хүрнээс улаан болж хувирдаг байна. Харин зэсийн орц ихтэй найрлага бүхий будгаар хээ тавьсан тохиолдолд ногоон өнгөтэй болдог ажээ. Дов дэрсийн хэрмийн түүвэр эдлэл дэх энэхүү шаргал, ногоовтор өнгөтэй шаазан нь Си Ся, Алтан улсын үеэс эхлэн Юань, Мин улсын үед уламжлагдсан технологийн хийцийн бүтээгдэхүүн байх боломжтой байна.

Дов дэрсийн хэрмээс баруун хойш 25 км зайд



Хэрлэнгийн Хөдөө аралд байрлах Аваргын балгас, зүүн тийш 50 км зайд орших зарим судлаачдын XIII зууны үед холбогдуулан үзсэн Хэрээ гэхөлийн хэрмийн турьтай харьцуулан үзвэл Дов дэрсийн хэрэм нь дурдсан хоёр байгууламжийн ойролцоо цаг үед баригдсан, Хэрлэн дагасан сүлжээ хот, бэхлэлтийн нэгэн төлөөлөл байх боломжтой билээ.

## Abstract

### THE STUDY OF NOMADIC CITY SETTLEMENT WITH DOUBLE-WALLED STRUCTURE (The ruins of Dov Ders serve as an example)

by Sodnom Ulziibayar and Enkhbayar Urtnasan

The ruins of the double-walled city in Mongolia were compared to the structure of the Dov Ders ruins on the southeast slope of Jargalant mountain in the Bayanmunkh soum area of Khentii Province, Mongolia, which is located to the east of Ulaanbaatar. Archeological evidence indicates that ancient Mongol states used the double-earth walls as a means of defense. We predict that the date of the ruins of Dov Ders may relate to the Mongol Empire period. The indication that 'city 城郭 (chéngguō) has outer and inner earthen walls' that were mentioned in ancient Chinese sources, could be the description of the double-walled structure found in Mongolia that covers a long period of history.

**Keywords:** Nomadic urbanism, early states, urban settlement, double wall, Dov Sersiin ruins, internal and external walled city

## Ном зүй

Амаргүвшин Ч., Гантулга Ж., Гарамжав Д. (2009). Мангасын хүрээ хэмээх нэгэн шороон хэрмийн тухай. *Acta historica*. Т.Х, F. 1-42, 36-37.

Батболд, Г. (2013). Хятаны ханзан халаалтын тухайд (Чинтолгой балгасаас илэрсэн ханзан халаалтын жишээн дээр). Нүүдэлчдийн өв судлал. Т.XV, Fasc 7., 50-58.

Батсайхан, З. (2002). Хүннү (Археологи, түүх, угсаатны зүй). Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.

Баяр, Д. (2002). Хөгшин Тээлийн балгас дахь анхны малтлага судалгаа. SH, Tom XXXIII, F.16., 166-167. Бродянский, Д. (1985). Кроуновское-хунские параллели. Древнее Забайкалье и его культурные связи., 49.

Давыдова, А. (1985). Иволгинский комплекс (городище и могильник)-памятник хунну в Забайкалье. Ленинград: Ленинградского уни-та.

Давыдова, А. (1995). Иволгинский археологический комплекс Т.2. Иволгинский городище. СПб.

Данилов, С. (2004). Города в кочевых обществах

Центральной Азии. Улан-Удэ. Улан-Удэ: БНЦ СОРАН.

Дашибалов, Б. (2003). Культура хунну как центральноазиатское явление. Мир Центральной Азии, 50- 63.

Доржсүрэн, Ц. (2004). Умард Хүннү УБ., 1961. Ц.Доржсүрэн. Археологийн судалгаа (эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл), 224.

Идэрхангай Т., Оргилбаяр С., Цэнд Д., Батчимэг Б., Амгаланбат Б., Эрдэнэпүрэв П., Баянсан П. (2020). Архангай аймгийн Өлзийт сумын нутаг дахь Харганынн хөндийд орших хүннүгийн хотын тууринд явуулсан малтлага судалгаа. Монголын археологи-2020., 26.

Киселев, С. (1957). Древние города Монголии. Советская археология. No2, 92.

Крадин Н.Н., Харинский А.В., Прокопцев С.Д., Ивлиев А.Л., Ковычев Е.В., Эрдэнэболд Л. (2020). Хятан улсын их хэрэм. Чингисийн далангийн зүүн хойд хэсгийн судалгаа. Улаанбаатар.

Кызласов, Л. (1969:61-62). История Тува: в средние века. Москва.

Очир А., Уртнасан Э. (2020). Монгол нутаг дахь Уйгурын хот суурингууд. Монголын археологийн өв. X боть. Улаанбаатар.

Өлзийбаяр С, Энхбат А. (2017). Жужан улс. Улаанбаатар: Соёмбо.

Өлзийбаяр С., Батсүрэн Б., Цэрэндагва Я., Очир Б., Уртнасан Э., Одмагнай Г., Цэгмэд Э. (2019). “Хүннүгийн дараах нүүдэлчид-II” экспедиц. 2019 онд Хэнтий аймгийн Баянмөнх, Мөрөн, Биндэр сумын нутагт ажилласан хээрийн судалгааны тайлан. Улаанбаатар: ШУА-ийн түүх, угсаатны зүйн хүрээлэн. Баримт мэдээллийн төв. CX-10, Д-1, ХН-60.

Өлзийбаяр, С. (2006). Аж ахуй. р. Ц.Цэрэнханд-Д. Эрт, дундад үеийн монголчуудын аж ахуй, соёл. (хууд. 43). Улаанбаатар: Цоморлиг төв.

Пэрлээ, Х. (1961). Монгол Ард Улсын эрт, дундад үеийн хот суурины товчоо. УБ.,: УХГ.

Руденко, С. (1962). Культура хуннов и Ноинулинские курганы. М.-Л.,

Сүхбаатар, Г. (2000). Монголчуудын эртний өвөг // Монголын эртний түүх судлал I боть. Улаанбаатар: Бемби сан.

Таскин, В. (1968). Материалы по истории Сюнну (по китайским источникам). Москва: Наук.

Таскин, В. (1984). Материалы по истории древних кочевых народов группы дунху. Введение, перевод и комментарии В.С. Таскина. Москва.

Хандсүрэн, Ц. (1966). Хөгшин Тээлийн хөшөөний бичээсийг унших нь. SH, Tom VI, Fasc II., 115.







Чингис хааны нийслэл Хархорум хотын өв. Монголын археологийн өв. XI боть. (2021). Улаанбаатар.






Эрэгзэн Г., Энхболд С. (2020). Монгол нутаг дахь Хүннүгийн хот суурингууд. Монголын археологийн өв. X боть. Улаанбаатар.







Давхар хэрэмт балгасны он цаг, хэмжээ, дэвсгэр зургийг харуулсан хүснэгт

Дурсгалын нэр	Он цаг	Хэрмийн хэмжээ (м)		Дэвсгэр зураг
		Гадна хэрэм	Дотор хэрэм	
Дов дэрсийн хэрмийн турь	Судалгааны эргэлтэд шинээр орж буй дурсгал. Монголын эзэнт гүрний үе.	215x215	100x110	
Харганын дөрвөлжин	Хүннү НТӨ III-НТ II зуун	553x553	265x265	
Мангасын хүрээ	Хүннү НТӨ III-НТ II зуун	595 голч	130x130	
Сайрын балгас	Хүннү НТӨ III-НТ II зуун	300x320	148x140	
Цагаан сүмийн балгас I	Уйгур	160x120	100x80	
Хэрэмтийн хөндий-1	Хятан	106x112	30x30	

Урд гэргийн говь	Хятан	Голч 160	60х60, 30х30	
Хар нуур-1	Хятан	105х107	30х30	
Хөгшин Тээлийн балгас I хэрэм	Монголын эзэнт гүрний үе	700х700х77 0х580		
Хөгшин Тээлийн балгас II хэрэм	Монголын эзэнт гүрний үе	430х350х45 0х460		
Хөгшин Тээлийн балгас III хэрэм	Монголын эзэнт гүрний үе	700х700		

Ханз хотын турь	Манж	955x955	855x855	
Тамир хотын турь	Манж	860x860	770x770	
Цагаан сүүл хотын турь	Манж	570x570	460x460	